



Хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн чадамжийн шаардлага  
2018 он

## ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙН МЭРГЭЖЛИЙН ЧАДАМЖИЙН ШААРДЛАГА

(Зөвлөмж)

*Энэхүү баримт бичгийг Монгол Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбооны Удирдах зөвлөлийн 2018 оны 12 сарын 7-ны өдрийн хурлаар хэлэлцэж дэмжив.*

### **Нэг. Ерөнхий**

Аливаа салбарт мэргэжлийн үйл ажиллагаагаа бүрэн хангалттай хэрэгжүүлэхийн тулд мэдлэгээ тогтмол дээшлүүлэх, ажлын байранд тавигдах ур чадварыг эзэмшсэн, зөв хандлагатай байх чадамжийг ажилтнаас шаарддаг.

Ажилтан мэргэжил эзэмшсэн байдлыг диплом, гэрчилгээ, дүнгийн хавсралт гэх мэт боловсролын албан ёсны баримт бичгээр баталгаажуулдаг. Мэргэжлийн мэдлэг, ур чадварыг их дээд сургуулийн сургалтаас гадна, практик үйл ажиллагаа, тасралтгүй сургалтын хослолоор олж авах боломжтой. Ийнхүү олж авсан мэдлэг, чадвар, дадлага туршлагыг боловсролын албан баримт гэхээсээ илүүтэйгээр шалгалт, ажлын түүх, лавлагаа захидал, ажил мэргэжлийн амжилт зэргээр баталгааждаг.

Ажил олгогчид мэргэжил эзэмшсэн төдийгүй мэргэжлийн ажлаа хангалттай биелүүлэх мэдлэг, ур чадвартай ажилтныг ажилд авахыг зорьдог. Нөгөө талаас ажилтан мэргэжлийн мэдлэг, ур чадвараа нотлон харуулж хүссэн ажилдаа орох, карьераа өсгөхийг хүсдэг. Ажил олгогч, ажилтны энэхүү бодит хэрэгцээнд суурилан “мэргэжлийн чадамж”-ийг тодорхойлох асуудал зүй ёсоор тавигдаж байна. Хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн чадамжийг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлсноор мэдлэг, ур чадварт суурилсан өрсөлдөөнийг дэмжиж, чадварлаг мэргэжилтнүүдийг бэлтгэх, хөдөлмөрийн эрүүл ахуйн салбарыг олон улсын жишигт хүргэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Энэхүү баримт бичиг нь хөдөлмөрийн эрүүл ахуйн үйл ажиллагааг эрхлэх мэргэжилтнүүдийг мэргэжлийн чадамжид тавигдах хамгийн доод түвшний шаардлагыг тодорхойлох зорилготой.

Хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн чадамжид тавигдах шаардлагыг боловсруулахад Хөдөлмөрийн эрүүл ахуйн олон улсын холбоо(International Occupational Hygiene Association), Үйлдвэрийн эрүүл ахуйн Америкийн холбоо(American Industrial Hygiene Association)-ноос зөвлөмж болгодог ижил төстэй баримт бичгүүдийг ашиглав. Энэхүү баримт бичгээр хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлийн аль нэг тодорхой сургалт, хөтөлбөрийг дүүргэхийг шаардаагүй. Харин хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжилтний зайлшгүй эзэмших шаардлагатай мэдлэг, гүйцэтгэх чадамжийг тодорхойлсон. Хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжилтэн бүрийн мэдлэг, ур чадвар эзэмшсэн замнал арга хэлбэр нь харилцан адилгүй байж болно.

## Хоёр. Нийтлэг тодорхойлолт

### Хөдөлмөрийн эрүүл ахуй

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль: Хөдөлмөрийн эрүүл ахуй гэж хөдөлмөрлөх явцад хими, физик, биологийн хүчин зүйлсээс шалтгаалан хүний бие махбодь, мэдрэл сэтгэхүйд өөрчлөлт орж өвчлөх, хөдөлмөрийн чадвар түр болон бүрэн алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэлнэ.
- Хөдөлмөрийн эрүүл ахуйн олон улсын нийгэмлэг: Хөдөлмөрийн эрүүл ахуй гэдэг нь ажилтнуудын эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хамгаалах, хамт олон / нийтийн аюулгүй байдлыг хангах зорилго бүхий ажлын орчин дахь эрүүл мэндэд аюултай хүчин зүйлсийн таньж илрүүлэх, хянах эдгээрийг төлөвлөх үйл ажиллагааг хэлнэ.
- Хөдөлмөрийн эрүүл ахуйн Америкийн холбоо: Үйлдвэрийн эрүүл ахуй нь ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг дээшлүүлэх, сайжруулах шинжлэх ухаан юм. Ажилчдын эрүүл мэнд аюулгүй байдалд ажлын байрны хими, физик, биологи, эргономикийн өргөн хүрээний хүчин зүйлс хамаарна.
- Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын Австралийн хүрээлэн: Хөдөлмөрийн эрүүл ахуй нь ажилчдын сайн сайхан байдалд нөлөөлдөг эсвэл гэмтэл бэртэл, өвчин эмгэг үүсгэдэг ажлын байрны аюултай хүчин зүйлсийг илрүүлэх, хэмжиж үнэлэх, мэдээлэх, түүнээс сэргийлэх, бууруулах үйл ажиллагааг төлөвлөх талаарх шинжлэх ухаан ба урлаг юм. Ажлын байрны аюултай хүчин зүйлс нь биологи, хими, физик, эргономик, нийгэм-сэтгэл бүлэгт хуваагдана.

### Хөдөлмөрийн эрүүл мэнд

- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага: Хөдөлмөрийн эрүүл мэнд гэдэг нь бүх төрлийн хөдөлмөр эрхэлдэг хүмүүст ажилтай холбоотой эрүүл мэндийн сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх, түүний эрсдэлийг хянах, ажил хөдөлмөртөө дасан зохицоход нь туслах замаар бие махбодь, сэтгэл зүй, нийгмийн сайн сайхан байдлыг хамгийн дээд түвшинд байлгахад чиглэсэн дэмжих үйл ажиллагаа, үйлчилгээ юм.
- ОУХБ-ын 161 дүгээр конвенц: “Хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээ” гэдэг нь ажил олгогч, ажилтан, тэдний төлөөлөлд зайлшгүй шаардлагатай урьдчилан сэргийлэлтийн үйлчилгээг дараах байдлаар хүргэхийг хэлнэ. Үүнд бие махбодь, сэтгэл зүйн таатай нөхцөлд хөдөлмөрлөх, аюулгүй, эрүүл ажлын орчинг бий болгох, ажилчдыг бие махбодь сэтгэл зүйн хувьд тааламжтайгаар хөдөлмөрлөх, ажилд дасан зохицоход дэмжих үйл ажиллагаа хамаарна.

### Хөдөлмөрийн эрүүл ахуйч

Хөдөлмөрийн эрүүл ахуйч нь ажилтай холбоотой үүссэн хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хими, физик, биологи, эргономикийн хүчин зүйлсийг таньж илрүүлэх, хэмжиж үнэлэх, сөрөг нөлөөллийг нь арилгах, бууруулах урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг төлөвлөх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг мэргэжилтэн.

### **Хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн чадамж**

Хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэхийн тулд ажилтны зайлшгүй эзэмшсэн байх шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагын нэгдэл юм.

### **Гурав. Хөдөлмөрийн эрүүл ахуйн эдийн засгийн үр нөлөө**

Хөдөлмөрийн эрүүл ахуйн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжсэнээр ажилтан, ажил олгогч, хэрэглэгч нарт дараах үр нөлөөг бий болгодог (ХЭА-н Америкийн холбоо, 2018 он). Үүнд:

- Ажилтны эрүүл мэнд, идэвхийг сайжруулж, дундаж наслалтыг нэмэгдүүлэх,
- Ажилтны шилжих хөдөлгөөн, ажил таслалтыг багасгах,
- Ажилтай холбоотой өвчлөлийн улмаас хөдөлмөрийн чадвар алдах, эрт тэтгэвэрт гарах тохиолдлын тоог бууруулах,
- Нийгмийн халамж, эрүүл мэндийн тусламжийн зардлыг бууруулж, ажилтны хөдөлмөрийн чадварыг хадгалах,
- Технологийн дэвшлийг нэвтрүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын зохион байгуулалт, бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийг сайжруулах боломжуудыг бий болгох,
- Зардал хэмнэх, зах зээлд бүтээгдэхүүн гаргах хугацааг бууруулах, хувьцааны үнэлгээг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн тоог тогтвортой байлгах хамаарна.

Дээрх үр нөлөө нь улс орны нийгэм, эрүүл мэнд, эдийн засгийн салбарт шууд дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой.

### **Дөрөв. Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын ажил эрхлэлт**

2018 онд эмхэтгэсэн “Монгол улс дахь Хөдөлмөрийн эрүүл мэндийн төлөв байдал эмхэтгэл”-д хөдөлмөрийн эрүүл ахуйч нар дараах байгууллагуудад хөдөлмөр эрхэлж байгааг тодорхойлжээ. Үүнд:

- Аж ахуйн нэгж байгууллагуудад хөдөлмөрийн эрүүл ахуйч, холбогдох бусад хөдөлмөрийн эрүүл ахуйн албан тушаалтнаар,
- Мэргэжлийн хяналтын байгууллагад хөдөлмөрийн эрүүл ахуйн байцаагч, шинжээчээр,
- Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудал хариуцсан төрийн байгууллагад хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжилтнээр,
- Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад багш, судлаачаар,
- Хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн зөвлөх байгууллагуудад хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжилтнээр,
- Хөдөлмөрийн эрүүл ахуйн лабораторид шинжээчээр, бусад албан тушаалтнаар,
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын төвүүдэд хөдөлмөрийн эрүүл ахуйн багшаар,
- Хөдөлмөрийн эрүүл ахуйн олон нийтийн байгууллагуудад ажиллаж байна.

### **Тав. Хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн чадамжид тавигдах шаардлага**

Хөдөлмөрийн эрүүл ахуйн практик үйл ажиллагаа нь ажлын орчны хүчин зүйлсийн өртөлтийг хэмжиж, үнэлэх, өртөлтийг бууруулах, арилгах хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгддэг. Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд физик, хими, биологи, эргономикийн сөрөг хүчин зүйлсээс биологийн тогтолцоонд үзүүлэх физиологийн харилцан үйлчлэл, хор судлал, ажлын байр болон орчны бохирдлоос ажилтны эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн талаар ойлголт мэдлэгтэй байхыг шаарддаг. Хөдөлмөрийн эрүүл ахуйч нь дараах чиглэлээр мэдлэг, чадамжтай байх шаардлагатай.

#### *А. Ажлын байрны сөрөг хүчин зүйлийн өртөлтийг үнэлэх, эрсдэлийн үнэлгээ хийх чадамж*

1. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас ажилтны эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй сөрөг хүчин зүйлсийг ажлын байранд ажиглалт хийх, үйлдвэрлэлийн технологит ашиглах түүхий эд, тоног төхөөрөмж, тэдгээртэй холбоотой баримт бичгийн стандарт, бусад мэдээлэл болон ажлыг гүйцэтгэдэг ажилтнуудтай ярилцах замаар олж, аюулыг таньж тогтоох;
2. Дээрх аюулын өртөлтөөс үүдэх эрүүл мэндийн сөрөг нөлөөлөл болон өртөлт хоорондын харилцан хамаарлыг хор судлал, тархвар судлалын зарчмууд, өртөлтийн зөвшөөрөгдөх хэмжээний талаарх батлагдсан стандарт, үйлдвэрлэгчээс гаргадаг материалын хор аюулын лавлах мэдээлэлд үндэслэн урьдчилан үнэлэх;
3. Сөрөг хүчин зүйлсийн өртөлтийн хэлбэлзэл, эрчмийг үнэлэх үр нөлөөтэй эрсдэлийн үнэлгээний стратегийг боловсруулж хэрэгжүүлэх;
4. Эрсдэлийн үнэлгээ, мэргэжлийн ур чадварт суурилан өртөлтийн тоон ба чанарын мэдээ баримтад дүн шинжилгээ хийх, эрүүл ахуйн үзүүлэлтийг холбогдох стандарт, удирдамжтай харьцуулах замаар ажилтны эрүүл мэндийн эрсдэлийг үнэлж, дүгнэх;
5. Шаардлагатай тохиолдолд өртөлтийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх арга зүйг зөвлөх;
6. Ажилтны эрүүл мэндийн эрсдэлийг үнэлэх ойлгомжтой тодорхой байдлаар тайлагнах, нэмэлт үнэлгээний хэрэгцээ тодорхойлогдвол олж илрүүлсэн үр дүнг мэдээлэх;

#### *Б. Хөдөлмөрийн эрүүл ахуйн урьдчилан сэргийлэлтийн хэрэгжүүлэх чадамж*

1. Сөрөг хүчин зүйлсийн өртөлтийг зөвшөөрөх хэмжээнд хүртэл бууруулах, арилгахад эрүүл ахуйн хяналтын арга хэмжээний шатлалын зарчимд суурилсан тохиромжтой аргыг сонгох;
2. Эрсдэлийн үнэлгээний үр дүн үндэслэн эрсдэлийг бууруулах арилгах зорилгоор хэрэгжүүлж буй инженерийн, удирдлага зохион байгуулалтын болон хувийн хамгаалах хяналтын арга хэмжээ, стандарт, арга туршлагын үр нөлөөг үнэлэх;
3. Шаардлагатай тохиолдолд хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх, үр нөлөөг баталгаажуулахтай холбоотой үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах;
4. Хэрэгжүүлж буй арга хэмжээний үр нөлөөг баталгаажуулах;

*В. Хөдөлмөрийн эрүүл ахуйн менежментийг хэрэгжүүлэх чадамж*

1. Хөдөлмөрийн эрүүл мэндийн бусад мэргэжилтэн, инженер, менежерүүдтэй хамтран ажилтны эрүүл мэндэд аюултай өртөлтийг үнэлэх, үр дүнг нь мэдээлэх, түүнийг бууруулах хяналтын арга хэмжээний талаар үр нөлөө бүхий удирдлагын тогтолцоог бий болгоход зөвлөмж өгөх;
2. Удирдах арга хэрэгсэл, үр нөлөөтэй харилцааны стратеги, эргэх холбоо бүхий тогтмол үнэлгээг ашиглан удирдлагын тогтолцооны шаардлагыг хэрэгжүүлэх;
3. Удирдлагын тогтолцооны суурь үзүүлэлтүүдийг холбогдох зохицуулалт, мэргэжлийн стандарт, сайн практиктай харьцуулан үе шаттайгаар үнэлэх;
4. Хөдөлмөрийн эрүүл ахуйн үйл ажиллагаанаас үүдэн ажилтнуудын эрүүл мэндэд нөлөөлөх ёс зүй, нийгэм, соёлын асуудлуудыг таньж тогтоох, анхааран ажиллах;

**Зургаа. Боловсролын суурь шаардлага**

Хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн чадамжийг эзэмшихийн тулд шинжлэх ухааны суурь мэдлэгийг дээд боловсролын сургалтаар эзэмшсэн байх, эрүүл ахуй-тархвар судлал, нийгмийн эрүүл мэнд судлал, хөдөлмөрийн эрүүл мэнд-аюулгүй байдал, орчин ба хөдөлмөрийн эрүүл мэндийн бакалавр, магистрын хөтөлбөрийг амжилттай дүүргэсэн байна.

*Хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн чадамжийн боловсролын суурь шаардлага*

Боловсролын зэргийн шаардлага Дээд боловсролын сургалтад 4 жилээс багагүй хугацаанд суралцсан, бакалаврын зэрэгтэй.

Шинжлэх ухааны суурь мэдлэг Эрүүл ахуй-тархвар судлал, нийгмийн эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл мэнд-аюулгүй байдал, орчин ба хөдөлмөрийн эрүүл мэндийн бакалавр, магистрын хөтөлбөрт суралцаж шинжлэх ухааны суурь мэдлэгийг эзэмшсэн байна.

ЭСВЭЛ дараах сэдвийг дээд боловсролын сургалт эсвэл тасралтгүй сургалтаар зайлшгүй судалсан байна.

- Байгалийн ухааны суурь хичээлүүд (хими, физик, биологи)
- Хүний биеийн анатоми, физиологи
- Биостатистик
- Тархвар судлал
- Хор судлал
- Хөдөлмөрийн эрүүл ахуй
- Эргономик
- Шуугиан ба физикийн аюултай хүчин зүйлс
- Мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын суурь ойлголт
- Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт хийх арга зүй
- Инженерийн хяналт ба Үйлдвэрийн агааржуулалт

- Хөдөлмөрийн эрүүл ахуйн хууль эрх зүй

Хөдөлмөрийн  
эрүүл ахуйн  
туршлага

4 жилээс багагүй хугацаанд хөдөлмөрийн эрүүл ахуйн туршлага хуримтлуулсан байна. Үүнд уг мэргэжлээр суралцсан хугацааг оролцуулан тооцно.

6 сараас цөөнгүй хугацаанд хөдөлмөрийн эрүүл ахуйн практик үйл ажиллагааг эрхэлсэн байна. Үүнд хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлээр их дээд сургуульд суралцаж байх үеийн үйлдвэрлэлийн дадлага, практик хичээл хамаарна.

### **Долоо. Мэргэжилтний ёс зүйн шаардлага**

Хөдөлмөрийн эрүүл ахуйч нь мэргэжлийн ёс зүйн дараах 6 зарчмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах нь зүйтэй. Үүнд:

1. Шинжлэх ухааны холбогдох салбаруудад суралцаж, туршлагажсан, мэргэжлийн итгэл үнэмшлээрээ гаргасан шийдвэр нь хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхныг хангах, хамгаалахад чиглэнэ.
2. Эрүүл мэндэд аюултай хүчин зүйлсэд өртсөн ажилтан, хамт олонд нотолгоонд суурилсан үнэн бодиттой мэдээлэл, зөвлөгөө өгч, үүсэж болзошгүй сөрөг үр дагаврын талаар урьдчилан анхааруулах үүрэгтэй.
3. Мэргэжлийн итгэл үнэмшлээрээ ажиллах боломжгүй нөхцөл байдалд орох, ашиг сонирхлын зөрчилд автахаас зайлсхийнэ.
4. Хөдөлмөрийн эрүүл ахуйч нь суралцаж, туршлага хуримтлуулж, зохих шалгуураар шалгагдсан мэргэжлийн салбар(хөдөлмөрийн эрүүл ахуйн)-таа ажил үүргээ гүйцэтгэх ба шаардлагатай тохиолдолд бусад мэргэжил(физик, хими, мэргэжлээс шалтгаалсан өвчин г.м)-ийн тусламжийг зохих шалгуур хангасан байгууллага эсвэл мэргэжилтнээс авах нь зүйтэй.
5. Мэргэжлийн үйл ажиллагаагаа гүйцэтгэх явцад олж мэдсэн хувь хүн, байгууллагын мэдээллийг чандлан нууцалж, зөвхөн хууль ёсны дагуу эсвэл эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх зорилгоор зохистой хэрэглэнэ.
6. Мэргэжлийн үнэнч шударга байдлыг дэмжин ажиллах үүрэг хамаарна.

Мэргэжилтний ёс зүйн энэхүү шаардлагыг Хөдөлмөрийн эрүүл ахуйн олон улсын холбоо, Үйлдвэрийн эрүүл ахуйн Америкийн холбоо, Монголын Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбооны “Мэргэжлийн ёс зүйн дүрэм”-д суурилан тодорхойлов.

### **Найм. Мэргэжлийн чадамжийн үнэлгээ**

Хөдөлмөрийн эрүүл ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг ажилтан нь сайн дурын үндсэн дээр мэргэжлийн чадамжаа үнэлүүлж болно. Хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн чадамжийн үнэлгээг дараах байдлаар хийх нь зүйтэй. Үүнд:



1. Урьдчилсан үнэлгээ: Ажилтны боловсролын баримт бичигт үндэслэн энэхүү зөвлөмжийн 6 дугаар хэсэгт заасан боловсролын суурь шаардлагыг хангаж байгаа эсэхийг үнэлнэ.
2. Чадамжийн үнэлгээ: Урьдчилсан үнэлгээгээр боловсролын суурь шаардлагыг хангасан ажилтны чадамжийн үнэлгээнд хамруулна. Чадамжийн үнэлгээгээр энэхүү зөвлөмжийн 5 дугаар хэсэгт заасан чадамжийг ажилтан эзэмшсэн эсэхийг сорил шалгалт, гардан үйлдлийн даалгавар, ярилцлага шалгалтын хэлбэрээр үнэлнэ.

Боловсруулсан:

Д.Нарансүх, АУ-ны доктор, МХЭАҮХ-ны удирдах зөвлөлийн гишүүн  
Э.Эрдэнэчимэг, АУ-ны доктор, дэд профессор, МХЭАҮХ-ны удирдах зөвлөлийн гишүүн  
З.Мөнхтуул, МХЭАҮХ-ны удирдах зөвлөлийн гишүүн